

ХУУЛЬЧИЙН ҮРГЭЛЖИЛСЭН СУРГАЛТЫН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ХОРООНЫ ГИШҮҮНД НЭР ДЭВШҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДАМЖ

Нэг.Зорилго

1.1.Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 53 дугаар зүйл, Монголын Хуульчдын холбооны дүрмийн 8.4 дүгээр зүйлд заасан Хуульчийн үргэлжилсэн сургалтын асуудал эрхэлсэн хороо (цаашид “Сургалтын хороо” гэх)-ны гишүүнд нэр дэвшүүлэх ажлыг зохион байгуулахад оршино.

Хоёр.Сургалтын хорооны бүрэлдэхүүнд төлөөллөө оруулах эрх бүхий этгээд, төлөөлөгчийн тоо

2.1. Сургалтын хороо нь шүүгч, прокурор, өмгөөлөгчдийн хорооноос тус бүр хоёр, хуульч профессоруудаас долоон төлөөлөл оролцсон, нийт арван гурван гишүүний бүрэлдэхүүнтэй байна.

Гурав.Нэр дэвшүүлэх үйл ажиллагаа

3.1.Сургалтын хорооны гишүүнд нэр дэвшүүлэх ажиллагааг 2023 оны 04 дүгээр сарын 19-ний өдрөөс 2023 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 12:00 цагийн хооронд явуулна.

3.2.Сургалтын хорооны гишүүнд нэр дэвших сонирхолтой хуульч өөрөө нэрээ дэвшүүлнэ.

3.3.Монголын Хуульчдын холбооны Зөвлөл нэр дэвшигчдээс энэ удирдамжийн 2.1 дэх хэсэгт заасан тооны хуульчийг Сургалтын хорооны гишүүнээр батална.

Дөрөв.Нэр дэвшигчид тавих шаардлага

4.1. Хуульчийн үргэлжилсэн сургалтын асуудал эрхэлсэн хорооны гишүүнд нэр дэвшигчид тавигдах шаардлага:

1. Тухайн хорооны гишүүн байх
2. Мэргэжлээрээ арваас доошгүй жил ажилласан;
3. Эрх зүйн тодорхой салбарт зургаагаас доошгүй жил мэргэшин ажилласан;
4. Магистр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй;
5. Сүүлийн 3 жилийн хугацаанд мэргэжлийн ёс зүйн зөрчил гаргасан үндэслэлээр хариуцлага хүлээгээгүй байх,
6. Хуульчийн нийтлэг үүргийн зөрчилгүй байх,

Тав.Бүрдүүлэх материал

5.1.Нэр дэвшигч нь дор дурдсан материалыг бүрдүүлж, Монголын Хуульчдын холбооны Тамгын газарт хүргүүлнэ:

1. Төрийн албан хаагчийн анкет, 2 хувь цээж зураг (4х6 хэмжээтэй);
2. Иргэний үнэмлэхний хуулбар;
3. Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хуулбар;
4. Хууль зүйн магистр ба түүнээс дээш боловсролын зэргийн дипломын хуулбар;

5. Мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан тухай нотлох баримт (Ажлын газрын тодорхойлолт эсвэл Нийгмийн даатгалын дэвтэр);
6. Магадлан итгэмжлэгдсэн хууль зүйн сургуульд профессорын ажил эрхэлдгийг нотлох баримт (тодорхойлолт);
7. Эрх зүйн тодорхой салбарт зургаагаас доошгүй жил мэргэшин ажилласан тухай нотлох баримт (Мэргэшин ажилласан чиглэлээр хийсэн бүтээлийн жагсаалт эсвэл эрх бүхий этгээдийн тодорхойлолт)
8. Ёс зүйн зөрчилгүй болохыг нотлох баримт

Зургаа.Материал ирүүлэх хугацаа, хаяг

6.1.Сургалтын хорооны гишүүнд нэр дэвшигчийн материалыг 2023 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 12:00 цаг хүртэл Монголын Хуульчдын холбооны Тамгын газар дор дурдсан хаягаар хүлээн авна:

Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо, Хууль зүйн үндэсний хүрээлэн, 4 давхар, 406 тоот

Холбоо барих утас: 70116065, 95735559, 95211288

-ooOoo-